



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Г Маягтад өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.7}, Жолоочийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 334 дүгээр тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт”-ын “6. Даатгалын хураамж” хэсэг дэх хүснэгтийн И₂ итгэлцүүрт хамаарах мөрөнд доор дурдсанаар өөрчлөлт оруулсугай:

1/

Өмнөх 1 жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын үед нөхөн төлбөр олгосон тоо, эсхүл тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн буруугаас үүссэн зам тээврийн ослын улмаас жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тооноос хамаарах И ₂	И ₂ =.....
---	-----------------------

2. Маягтад оруулсан өөрчлөлтийг 2015 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Маягтад өөрчлөлт орсонтой холбогдуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Албан журмын даатгагчдын холбоо /Б.Нямдорж/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын өөрчлөлтийг “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт”-д тусгаж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрад/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000920